



**Бид бусдын соёлыг хэрхэн
ойлгож, хүндэтгэх ёстой вэ?**



- Чи ямар шашин шүтдэг вэ? Танай гэрийнхэн ямар шашин шүтдэг вэ?

-

- Чи ямар кино үзэх, дуу сонсох дуртай вэ? Танай гэр бүлийнхэн ямар дуу сонсох дуртай вэ?

-

- Чи чөлөөт цагаараа юу хийх дуртай вэ? Чиний найз чөлөөт цагаараа юу хийх дуртай вэ?

Хэл, уламжлал, ёс заншил

Шашин шүтлэг, хоол, хувцас

Соёлын олон янз
байдал

Урлаг, дуу хөгжим, бүжиг

Баяр ёслол, тэмдэглэлт үйл явдал



Соёлын олон янз байдал нь хувь хүн, гэр бүл, сургууль бүр өөрийн онцлогтой байдагтай шууд холбоотой бөгөөд хувь хүний болон нийгмийн бүлгүүдийн соёлын сонголтын ялгаатай байдлыг илэрхийлдэг ойлголт юм.



Соёлын олон янз байдал нь
бусдын соёлын үнэт зүйлсийг
тэтгэн хөгжүүлж, соёлын
олон талт баялаг ертөнцийг
бий болгодог.

Соёлын зөрчилдөөн

Хэл, уламжлал, ёс заншил, шашин шүтлэг, үнэлэмж, үзэл бодлын ялгаатай байдлаас үүсэх мөргөлдөөн юм.



Соёлын зөрчилдөөнийг шийдэх нэг арга зам бол соёл болгон өөрийн онцлогтой, бас үнэ цэнтэй байдгыг ойлгож хүндэтгэлтэй хандах явдал юм. Соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэх нь өнөөгийн нийгмийн тогтвортой хөгжлийн нэг чухал хүчин зүйл болно.

- 1-р баг
- Соёл яагаад ялгаатай байдаг талаар баримтаар нотлон жишээ гаргаж бичих
- 2-р баг
- Сургуулийн орчинд бусдын соёлыг хэрхэн ойлгох, хүндэтгэх тухай зураглал хийх
- 3-р баг
- Бусдын соёлыг ойлгохгүй байснаар үүдэх соёлын сөрөг үр дагаврыг жишээ гарган бичнэ үү

Бид соёлын ямар хэм хэмжээг өөрт суулгах, баримтлах хэрэгтэй вэ? Хүснэгтийг гүйцээж бичээрэй

№	Соёлын олон янз байдлын нөхцөлд баримтлах хэм хэмжээ	Түүнийг хэвшүүлэх арга зам
1	Эелдэг, найрсаг байх	
2	Хүлээцтэй байдлыг эрхэмлэх	
3	Уучлал хүсдэг, уучилдаг байх	
4	Хүндэтгэх, халамж анхаарал тавих	
5		
6		
7		
8		
9		

Хичээлд идэвхтэй оролцсонд баярлалаа